

# СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Халзан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2024/12/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Баруун-Урт хот

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Даваа

Утас: 70518369 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер: Ц.Нарантуяа

Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Аудитор: О.Барчидгүнсэн

Утас: 70512127 Цахим хаяг: barchidgunseno @audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

ХАЛЗАН СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Г. АЛТАНСҮХ ТАНАА

2024.03.25 № 274  
танай \_\_\_\_\_ - ны№ \_\_\_\_\_ -Т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Халзан сумын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Халзан сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Эмийн эргэлтийн сангийн эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийг орон нутгийн хөрөнгөөс хасаж эзэмшигчдэд шилжүүлэх Аймгийн ИТХ-ын 2023 оны 08 тоот тогтоол гарсантай холбоотойгоор Эмийн эргэлтийн санхүүгийн тайланг ТТЗ-ын тайланд нэгтгээгүй байна.

### Аудитын гол асуудал

Байгалийн нөөц ашигласны төлбөр 76.0 сая, цалин түүнтэй адилтгах орлого 44.1 сая төгрөгөөр давсан бөгөөд үйл ажиллагааны орлого 7.6 сая, хөрөнгийн албан татвар 23.6 сая, бууны албан татвар 0.3 сая, малд ногдуулах албан татвар 44.0 сая, хог хаягдлын үйлчилгээний хураамж 8.7 сая нийт 84.2 сая төгрөгийн орлого тасарчээ.

### Бусад асуудлын хэсэг

Сүхбаатар аймгийн Халзан сумын Засаг даргын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 14 зорилт, 63 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 86.6 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	753,829,368.95	952,661,473.46
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	521,087,905.77	669,368,453.28
33	АВЛАГА	165,768,370.00	211,806,154.00
33500	Бусад авлага	149,818,370.00	210,728,154.00
35	БАРАА МАТЕРИАЛ	56,593,093.18	56,406,866.18
35100	Түүхий эд материал	24,591,127.00	0
35400	Хангамжийн материал	27,001,966.18	31,406,866.18
36	НӨӨЦИЙН БАРАА	10,380,000.00	15,080,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,695,882,368.49	2,777,165,244.67
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,695,882,368.49	2,777,165,244.67
39200	Биет хөрөнгө	1,671,797,518.49	2,142,274,394.67
39300	Биет бус хөрөнгө	24,084,850.00	634,890,850.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,449,711,737.44	3,729,826,718.13
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	96,029,537.75	90,020,439.17
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	96,029,537.75	90,020,439.17
41300	Өглөг	24,724,024.13	33,362,728.72
41360	Бусад өглөг	24,724,024.13	18,554,202.72
41400	Урьдчилж орсон орлого	71,305,513.62	56,657,710.45
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,353,682,199.69	3,639,806,278.96
51	Засгийн газрын хувь оролцоо	2,353,682,199.69	3,639,806,278.96
51200	Хуримтлагдсан үр дүн	935,419,877.69	1,614,203,873.96
51210	Өмнөх үеийн үр дүн	5,160,052,411.51	935,419,877.69
51220	Тайлант үеийн үр дүн	-4,224,632,533.82	678,783,996.27
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	165,028,920.83	165,028,920.83
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,449,711,737.44	3,729,826,718.13

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,451,699,679.23	2,306,384,034.15
11	ТАТВАРЫН ОРЛОГО	398,177,219.93	367,623,525.81
110	Орлогын албан татвар	147,879,422.31	155,874,834.58
1100	Хувь хүний орлогын албан татвар	147,879,422.31	155,874,834.58
113	Хөрөнгийн албан татвар	80,794,680.62	60,067,600.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	169,503,117.00	151,681,091.23
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,237,600.00	2,505,919.89
1181	Газрын төлбөр	986,917.00	10,720,284.33
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	159,861,600.00	107,390,000.00
1183	Бусад татвар	6,417,000.00	31,064,887.01
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	340,629,248.42	744,960,550.34
120	Нийтлэг татварын бус орлого	340,629,248.42	744,960,550.34
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,004,848.10	10,729,189.26
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,712,893,210.88	1,193,799,958.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	167,334,900.00	325,407,100.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	167,334,900.00	325,407,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,564,822.00	28,416,858.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,635,100.00	5,913,020.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,929,722.00	22,503,838.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,532,709,178.30	839,976,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,098,625,625.03	0

132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	44,165,853.27	0
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	389,917,700.00	839,976,000.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>284,310.58</b>	<b>0</b>
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	284,310.58	0
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,121,324,744.93</b>	<b>1,454,843,800.46</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,121,324,744.93</b>	<b>1,454,843,800.46</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,201,737,103.17</b>	<b>1,432,555,200.46</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	352,951,737.63	505,174,208.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,989,903.48	60,275,100.53
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	275,427,690.97	40,431,944.60
2104	Хангамж, бараа материалын зардал	29,368,451.22	53,470,358.00
2105	Нормативт зардал	69,992,787.69	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,183,200.00	3,451,560.00
2107	Томилолт, зочны зардал	10,517,000.00	6,550,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	242,191,946.21	472,628,299.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	143,114,385.97	290,573,328.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	919,587,641.76	22,288,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,521,845.00	22,288,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	881,065,796.76	0
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	832,318,625.03	0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	48,462,861.15	0
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	284,310.58	0
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>330,374,934.30</b>	<b>851,540,233.69</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>4,555,007,468.12</b>	<b>199,877,058.42</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0	87,249.42
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	4,349,895,172.89	175,198,682.00
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	205,112,295.23	24,591,127.00
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-4,224,632,533.82</b>	<b>651,663,175.27</b>

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,812,439,612.69	416,497,813.86	3,532,334,368.32	6,761,271,794.87
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,559,206,211.52	-251,468,893.03	1,627,718,043.19	-182,957,061.36
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,253,233,401.17	165,028,920.83	5,160,052,411.51	6,578,314,733.51
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-4,224,632,533.82	-4,224,632,533.82
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,253,233,401.17	165,028,920.83	935,419,877.69	2,353,682,199.69
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,253,233,401.17	165,028,920.83	935,419,877.69	2,353,682,199.69
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-4,263,917.00	0	27,120,821.00	22,856,904.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,248,969,484.17	165,028,920.83	962,540,698.69	2,376,539,103.69
17	Өмчид гарсан өөрчилөлт	611,604,000.00	0	0	611,604,000.00
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	651,663,175.27	651,663,175.27
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,860,573,484.17	165,028,920.83	1,614,203,873.96	3,639,806,278.96

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,518,153,665.80</b>	<b>1,797,134,667.15</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>398,177,219.93</b>	<b>367,623,525.81</b>
110	Орлогын албан татвар	147,879,422.31	155,874,834.58
1100	Хувь хүний орлогын албан татвар	147,879,422.31	155,874,834.58
113	Хөрөнгийн албан татвар	80,794,680.62	60,067,600.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	169,503,117.00	151,681,091.23
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,237,600.00	2,505,919.89
1181	Газрын төлбөр	986,917.00	10,720,284.33

1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	159,861,600.00	107,390,000.00
1183	Бусад татвар	6,417,000.00	31,064,887.01
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	400,481,434.99	234,511,183.34
120	Нийтлэг татварын бус орлого	400,481,434.99	234,511,183.34
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	43,015,275.00	34,821,822.26
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	43,015,275.00	34,821,822.26
120009	Бусад орлого	38,426,410.00	3,005,430.58
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	318,414,749.99	192,811,930.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,719,495,010.88	1,194,999,958.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	167,334,900.00	325,407,100.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	167,334,900.00	325,407,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,166,622.00	29,616,858.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,635,100.00	5,913,020.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,531,522.00	23,703,838.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,532,709,178.30	839,976,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,098,625,625.03	0
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	44,165,853.27	0
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	389,917,700.00	839,976,000.00
1330	Төсвийн захирагчдаас	284,310.58	0
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	284,310.58	0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,157,094,030.35	1,295,587,347.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,157,094,030.35	1,295,587,347.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,196,688,039.32	1,272,561,427.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	428,876,686.63	577,136,496.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,396,284.94	81,212,528.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	282,752,525.81	47,801,884.25
2104	Хангамж, бараа материалын зардал	152,426,738.94	102,235,491.20
2105	Нормативт зардал	73,156,885.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,898,200.00	6,190,893.00
2107	Томилолт, зочны зардал	10,517,000.00	6,550,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,522,976.00	302,349,949.07
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	104,140,742.00	149,083,784.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	960,405,991.03	23,025,920.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,716,068.00	23,025,920.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,581,006.00	8,399,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	881,065,796.76	0
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	832,318,625.03	0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	48,462,861.15	0
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	284,310.58	0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	38,624,126.27	0
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	38,624,126.27	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	361,059,635.45	501,547,319.51
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	296,018,430.00	266,266,772.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	296,018,430.00	266,266,772.00
2200	Дотоод эх үүсвэрээр	296,018,430.00	266,266,772.00
220001	Барилга байгууламж	77,392,000.00	48,154,000.00
221001	Их засвар	59,499,600.00	0
222001	Тоног төхөөрөмж	1,625,000.00	98,516,000.00
223001	Бусад хөрөнгө	16,767,400.00	25,786,782.00

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	140,734,430.00	93,809,990.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-296,018,430.00</b>	<b>-266,266,772.00</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>-110,000,000.00</b>	<b>-87,000,000.00</b>
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>110,000,000.00</b>	<b>87,000,000.00</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	110,000,000.00	87,000,000.00
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>-44,958,794.55</b>	<b>148,280,547.51</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	566,046,700.32	521,087,905.77
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	521,087,905.77	669,368,453.28

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,938,012,600.00</b>	<b>1,423,055,261.33</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,243,787,600.00</b>	<b>1,163,598,479.33</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,220,707,800.00</b>	<b>1,140,572,559.33</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	553,705,000.00	505,174,208.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,916,600.00	60,275,100.53
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	249,037,800.00	232,678,559.88
2104	Хангамж, бараа материалын зардал	29,065,300.00	29,017,665.00
2105	Нормативт зардал	250,000.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	65,119,000.00	64,130,193.00
2107	Томилолт, зочны зардал	9,062,500.00	6,452,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,050,000.00	29,949,758.37
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	218,501,600.00	212,895,074.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,079,800.00	23,025,920.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,079,800.00	23,025,920.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>564,675,000.00</b>	<b>172,456,782.00</b>
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>129,550,000.00</b>	<b>87,000,000.00</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	129,550,000.00	87,000,000.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,938,012,600.00</b>	<b>1,631,320,201.59</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>328,289,000.00</b>	<b>325,407,100.00</b>
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	328,289,000.00	325,407,100.00
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,402,337,600.00</b>	<b>1,271,091,279.33</b>
320001	Орон нутгийн төсвөөс	1,402,337,600.00	1,271,091,279.33
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>207,386,000.00</b>	<b>34,821,822.26</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	58,000,000.00	34,821,822.26
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	149,386,000.00	0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	177,445,222.58
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	385,710,162.84
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>52</b>	<b>52</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>2</b>	<b>2</b>
610001	Төсвийн байгууллага	2	2
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>25</b>	<b>25</b>
620001	Удирдах ажилтан	8	8
620002	Гүйцэтгэх ажилтан	14	14

620003	Үйлчлэх ажилтан	3	3
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>25</b>	<b>25</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11	11
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7	7
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7	7

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>29,616,858.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>29,616,858.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>27,791,798.23</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>6,469,778.23</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,058,220.00</b>
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>830,000.00</b>
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>98,400.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>16,700,000.00</b>
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,635,400.00</b>
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,825,059.77</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,825,059.77</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,825,059.77
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>29,616,858.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>29,616,858.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,913,020.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	23,703,838.00

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Халзан сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитыг 2024 оны 3 дугаар сарын 15 -аас 2024 оны 3 дугаар сарын 25 -ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2024 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Засаг даргад хүргүүлэхээр төлөвлөн, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Г.Даваа, аудитын менежер М.Нарантуяа нар үе шатны хяналтыг хэрэгжүүлж, аудитор О.Барчидгүнсэн гүйцэтгэв.

### 4.2 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт 1,244.5 сая төгрөгийн зардлын 1.5 хувь буюу 18.6 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

### 4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Халзан сумын Засаг даргад хамаарах горим сорил хэрэгжүүлсэн.

Байгууллагын бүртгэлд байгаа авто тээврийн хэрэгсэлд бусад тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаарыг хэрэглэж Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ” заалтыг хэрэгжүүлжээ.

#### 4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант онд гарсан өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гаргасан тушаал шийдвэр, орлого зарлагын мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулжээ.

#### 4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар бичнэ.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар	Биелэлт
----------	----------------	---------

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	0	1	0	100
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>100</b>

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 84.2 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 84.2 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **Орлоготой холбоотой асуудал**

##### 5.1.1 Илрүүлэлт:

Орон нутгийн төсвийн орлого нь 84.2 сая төгрөгөөр тасарч, төлөвлөсөн хөтөлбөр арга хэмжээ хэрэгжихгүй байх эрсдэлтэй асуудал үүсэж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дугаар зүйлийн 41.2.1 дэх заалт (хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх), Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаал "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-тай тус тус нийцээгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн дагуу татварын болон татварын бус орлогыг үндэслэлтэй төлөвлөж, төлөвлөгөөг биелүүлэх чиглэлээр татварын байцаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тодорхой арга хэмжээ болгон тусгаж биелэлтийг хангуулж ажиллах.

#### **Тээвэр, шатахууны зардалтай холбоотой асуудал**

##### 5.1.2 Илрүүлэлт:

Албан ажлын автомашинуудад мэдээлэл, хяналтын төхөөрөмж буюу GPS суурилуулаагүй нь Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, сангийн сайдын 2022.12.23-ны өдрийн 95/260 дугаартай хамтарсан тушаалаар батлагдсан "Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам"-ын 4.2 дахь "Алба ажлын автомашин нь Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598 стандартын шаардлагыг хангасан байна." заалт, Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598 стандартын 8.4.3, 11.1 дэх заалттай нийцэхгүй байна. Албан ажлын автомашинуудад GPS суурилуулаагүй нь шатахууны зардалд хэмнэлт бий болохгүй байх сөрөг үр дагавартай байна.

#### Өгсөн зөвлөмж:

Албан ажлын автомашинуудад MNS 4598 стандартад заасан мэдээлэл, хяналтын төхөөрөмж буюу GPS суурилуулж, жолоочийн тооцооны хуудаг автомашин явсан маршрутыг жолоочоор GPS-ийн мэдээлэлд үндэслэн дэлгэрэнгүй бичүүлж, хяналт тавьж, шатахууны зардалд хэмнэлт бий болгож ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

